



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 9/410

Мандалговь

Г.Чагдаржавын мэндэлсний 150 жилийн
ойг тэмдэглэн өнгөрүүлэх салбар комисс
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор батлагдсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам”-ын 6 дугаар бүлгийн 6.9 дэх заалт, 2019 оны 265 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монгол төрийн нэрт зүтгэлтэн, 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалын манлайлагчдын нэг, Түр Засгийн газрын Ерөнхийлөн Захиран Шийтгэх газрын дарга, Монгол Улсын Сангийн Хамаг Хэргийг Бүгд Захиран Шийтгэгч Яамны анхны Тэргүүн сайд, Олон Монголчуудыг илбэн тохинуулах сайд, дипломатч, Түшээт засаг хошой чин ван, Говь түшээ гүний хошууны Засаг ноён Гадинбалын Чагдаржавын мэндэлсний 150 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх салбар комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Салбар комиссын ахлагч: А.Нарантуяа (Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүдэд:

Б.Түвшинбаяр (Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

О.Батчулуун (Дэлгэрхангай сумын Засаг дарга)

Р.Мөнхтогтох (Сайнцагаан сумын Засаг дарга)

Ш.Гансүх (Цэргийн штабын дарга)

Ш.Оюун (Үйлчилгээний албаны дарга)

М.Бямбажав (Музейн захирал)

Хоёр. Г.Чагдаржавын мэндэлсний 150 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх улсын комисстой хамтран ажиллахыг салбар комисс (А.Нарантуяа)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488191150